

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 05 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024-06-03

Баруун-Урт

Хяналт шалгалтын мэдээлэл:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2024 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02, 03, 04 тоот дотоод аудитын удирдамжийн дагуу сумдын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, Хүүхдийн цэцэрлэгүүдийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт, аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06, 07, 08 тоот санхүүгийн хяналт шалгалтын удирдамжийн дагуу сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Соёлын төвүүдийн 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгдэж байна. Албаны даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 05 тоот санхүүгийн хяналтын удирдамжийн дагуу аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгдэж шалгалтаар илэрсэн 44701.1 мянган төгрөгийн зөрчилд 5 заалттай хугацаатай албан шаардлага хүрүүлээ.

Бусад мэдээлэл:

Төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох сургалтад албаны Архив, бичиг хэрэг, Хүний нөөцийн ажилтан, Цахим хариуцсан ажилтнууд хамрагдлаа.

Мөн 7 хоног бүрийн бямба гарагт зохион байгуулагдаж байгаа “Илүүдэл жингүй, эртэч Сүхбаатарчууд” бүх нийтийн гүйлтэд оролцож байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

НЯГТЛАН БОДОГЧ

Б.УЯНГАНЯМ